

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТУСГААРЛАН БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид ҮЦТХТ гэх/ -ийн төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй Засгийн газрын өрийн хэрэгслээр /цаашид өрийн хэрэгсэл гэх/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчигээ худалдан авах тухай хуульд заасан тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахтай холбогдуулан үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журам нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад журам, заавраас бүрдэнэ.

1.3 Энэхүү журмын дагуу 3 ба түүнээс дээш сарын хугацаатай гаргасан Засгийн газрын өрийн хэрэгслийг төлбөрийн баталгаа хэлбэрээр ашиглана.

Хоёр. Баталгааны төрөл

2.1 Төвлөрсөн хадгаламжаас гаргах баталгаа нь дараах төрөлтэй байна. Үүнд:

2.1.1 Тендерийн баталгаа – Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д заасныг;

2.1.2 Гүйцэтгэлийн баталгаа – Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17-д заасныг ;

2.1.3 Урьдчилгаа төлбөрийн баталгаа – Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-т заасныг;

Гурав. Баталгаа гаргахад баримтлах шаардлага

3.1 Харилцагчид баталгаа гаргуулахтай холбогдуулан дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1 Үнэт цаас нь тухайн этгээдийн хууль ёсны өмч мөн байх;

3.1.2 Тухайн өмчлөгчийн өрийн хэрэгсэлд үүрэг ногдуулсан бүртгэл хийгдсэн байх;

3.1.3 Тухайн өрийн хэрэгсэлтэй холбоотойгоор хууль, шүүхийн байгууллагад өмчлөх эрхийн талаар маргаан үүсээгүй байх;

3.1.4 Харилцагч нь өрийн хэрэгслийг баталгааны хугацаа дуустал бусдад шилжүүлэхгүй, арилжаалахгүй байх;

3.1.5 Баталгааны хүчинтэй байх хугацаа нь өрийн хэрэгслийн хүчин төгөлдөр байх хугацаанд багтаж байх.

3.2 Журмын 3.1-д заасан материалуудыг гүйлгээ хариуцсан ажилтан шалгаж, шаардлага хангаж байгаа тохиолдолд тусгаарлах гүйлгээг хийх бөгөөд өрийн хэрэгсэлтэй холбоотойгоор хууль, шүүхийн байгууллагад өмчлөх эрхийн талаар маргаан үүссэн тухай

бүртгэл, мэдэгдэл эрх бүхий байгууллагаас ирж, тусгаарласан тохиолдолд тухайн шийдвэрийг гаргасан эрх бүхий ажилтан эсхүл удирдах албан тушаалтнаас шийдвэрийг хүчингүй болсон тухай мэдэгдэл ирэх хүртэл хугацаанд энэ журмын дагуу тусгаарлалтанд бүртгэхийг хориглоно.

Дөрөв. Өрийн хэрэгслээр гэрчлэгдсэн өмчлөх эрхээр баталгаа гаргах, баталгааг цуцлах, дуусгавар болгох, өмчлөх эрх шилжүүлэх

4.1 Харилцагчийн өрийн хэрэгслээр гэрчлэгдсэн өмчлөх эрхээр баталгаа гарган тусгаарлахад дараах баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1 Харилцагчийн албан бичгээр гаргасан хүсэлт;

4.1.2 Тухайн өмчлөгчийн өрийн хэрэгсэлд үүрэг ногдуулсан бүртгэл хийгдсэн баримт;

4.1.3 Үнэт цаас нь тухайн харилцагчийн хууль ёсны өмч мөн эсэх талаар баталгаа;

4.1.4 Тендерийн баталгаа гаргах тохиолдолд тендерийн урилга;

4.1.5 Гүйцэтгэлийн баталгаа гаргах тохиолдолд тендерт шалгарсан тухай захиалагчийн мэдэгдэл;

4.1.6 Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргах тохиолдолд захиалагч байгууллагатай байгуулсан гэрээ;

4.1.7 Харилцагч нь өрийн хэрэгслийг баталгааны хугацаа дуусах хүртэлх хугацаанд бусдад шилжүүлэхгүй, арилжаалахгүй байх үүрэг хүлээх тухай эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамгаар баталгаажуулсан, албан бичгээр ирүүлсэн баталгаа;

4.1.8 Харилцагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7–д заасан нөхцөл үүссэн тохиолдолд тусгаарласан өрийн хэрэгслийг улсын орлого болгоход татгалзахгүй тухай эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамгаар баталгаажуулсан, албан бичгээр ирүүлсэн баталгаа.

4.2 Журмын 4.1-т заасан баримт бүрэн бүрдсэн тохиолдолд Засгийн газрын өрийн хэрэгслээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг тусгаарлалтаас чөлөөлөх хүсэлт ирүүлэх хүртэл хугацаагаар түр тусгаарлан бүртгэнэ.

4.3 Баталгааны хүчинтэй байх хугацаа нь өрийн хэрэгслийн хүчин төгөлдөр байх хугацаанд багтсан байна.

4.4 Өрийн хэрэгслээр баталгаа гаргахдаа Сангийн сайдын тушаалаар батлагдсан холбогдох тендерийн жишиг баримт бичгүүдэд заасан маягтын дагуу гаргаж, уг баталгаанд үнийн дүн, хүчин төгөлдөр байх хугацааг тодорхой зааж өгнө.

4.5 ҮЦГХТ дараах тохиолдолд энэ журмын дагуу тусгаарласан өрийн хэрэгслийг чөлөөлнө.

Үүнд:

4.5.1 Тендерийн баталгаа гарган тусгаарлуулсан тохиолдолд:

4.5.1.1 Харилцагчийн бичгээр гаргасан хүсэлт;

4.5.1.2 Захиалагчтай байгуулсан гэрээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/ эсвэл захиалагч талын тусгаарлалтаас баталгааг чөлөөлөх тухай мэдэгдэл, зөвшөөрөл;

4.5.2 Гүйцэтгэлийн баталгаа гаргаж тусгаарласан тохиолдолд:

4.5.2.1 Харилцагчийн бичгээр гаргасан хүсэлт;

4.5.2.2 Ажил дууссан тухай захиалагчтай байгуулсан гэрээ дүгнэсэн акт эсвэл захиалагч талын тусгаарлалтаас баталгааг чөлөөлөх тухай мэдэгдэл, зөвшөөрөл;

4.5.3 Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаж тусгаарласан тохиолдолд:

4.5.3.1 Харилцагчийн бичгээр гаргасан хүсэлт;

4.5.3.2 Захиалагчаас урьдчилгаа төлбөрийн баталгааг цуцалж болох тухай албан бичиг.

4.6 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасан үндэслэлийн дагуу тусгаарласан баталгааг улсын орлого болгоно.

Тав. Үйлчилгээний шимтгэл

5.1 Энэ журмын дагуу баталгаа гаргахтай холбоотой шимтгэл болон журмын дагуу гэрээ дүгнэсэн актыг үндэслэн үнэт цаасыг захиалагчид шилжүүлэх гүйлгээний шимтгэлүүдийг харилцагч нь төвлөрсөн хадгаламжид өөрийн нэр дээр урьдчилан данс нээлгэн дансандаа байршуулах шаардлагатай.

5.2 Энэ журмын дагуу тусгаарлуулах болон үүргийн гүйцэтгэл хангагдаагүй захиалагчид өрийн хэрэгслийг шилжүүлэх тохиолдолд өрийн хэрэгслийн шимтгэлийг тооцохдоо өрийн хэрэгслийн нэрлэсэн үнээс бодож тооцно.

5.3 Баталгааг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд тусгаарлалтын шимтгэлийг буцаан олгохгүй.

5.4 Өрийн хэрэгслийн баталгаа гаргах замаар тусгаарлахтай холбоотой шимтгэлийг харилцагч хариуцна.

5.5 Өрийн хэрэгслийг энэ журмын 5.1-д заасан үндэслэлээр тусгаарлалтанд бүртгэхтэй холбоотой үйлчилгээний шимтгэлийг хоног тутамд энэ журмын 1-р хавсралтад зааснаар, гэрээ дүгнэсэн актын дагуу өрийн хэрэгслийг захиалагч талд шилжүүлэх тохиолдолд энэ журмын 2-р хавсралтын дагуу тус тус үйлчилгээний шимтгэл тооцно.

Зургаа. Хадгалалт, нууцлалт

6.1 Гүйлгээтэй холбоотой мэдээ, мэдээллийн хадгалалт, нууцлалтыг “ҮЦТХТ-ийн дотоод журам”, “Нууцын тухай журам”, “Мэдээллийн аюулгүй байдлын журам”-аар тус тус зохицуулна.

6.2 Гүйлгээ хариуцсан ажилтан баримтын бүрдэлт, хадгалалт, нууцлалыг бүрэн хариуцна.

Долоо. Хариуцлага

7.1 Энэхүү журмыг зөрчсөн ажилтан хариуцлагыг бүрэн хүлээх ба Гүйцэтгэх захирлын тушаалаар “ҮЦТХТ” ХХКомпанийн Дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

7.2 Энэ журмын 5.1-д заасны дагуу үйлчилгээний шимтгэлийн мөнгийг байршуулаагүйн улмаас гүйлгээ хийгдээгүй тохиолдол харилцагч болон захиалагчид үүсэх аливаа хохирлыг ҮЦТХТ хариуцахгүй.

Найм. Бусад

8.1 Энэхүү журамд ҮЦТХТ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.

“Засгийн газрын өрийн хэрэгслийг тусгаарлан бүртгэх журам”-ын хавсралт 1
Засгийн газрын өрийн хэрэгслийг тусгаарлалтанд бүртгэхэд тооцох шимтгэл

50 сая хүртэл төгрөг	0.001 хувь
50 саяас 100 сая хүртэл төгрөг	Суурь 500 төгрөг дээр 50 саяас давсан дүнгийн 0.0009 хувиар
100 саяас 150 сая хүртэл төгрөг	Суурь 950 төгрөг дээр 100 саяас давсан үнийн дүнгийн 0.0008 хувиар
150 саяас 200 сая хүртэл төгрөг	Суурь 1 350 төгрөг дээр 150 саяас давсан үнийн дүнгийн 0.0007 хувиар
200 саяас 250 сая хүртэл төгрөг	Суурь 1 700 төгрөг дээр 200 саяас давсан үнийн дүнгийн 0.0006 хувиар
250 саяас 300 сая хүртэл төгрөг	Суурь 2 000 төгрөг дээр 250 саяас давсан үнийн дүнгийн 0.0005 хувиар
300 саяас 350 сая хүртэл төгрөг	Суурь 2 250 төгрөг дээр 300 саяас давсан үнийн дүнгийн 0.0004 хувиар
350 саяас 400 сая хүртэл төгрөг	Суурь 2 450 төгрөг дээр 350 саяас давсан үнийн дүнгийн 0.0003 хувиар
400 саяас 450 сая хүртэл төгрөг	Суурь 2 600 төгрөг дээр 400 саяас давсан үнийн дүнгийн 0.0002 хувиар
450 саяас 500 сая хүртэл төгрөг	Суурь 2 700 төгрөг дээр 450 саяас давсан үнийн дүнгийн 0.0001 хувиар
500 саяас 550 сая хүртэл төгрөг	Суурь 2 750 төгрөг дээр 500 саяас давсан үнийн дүнгийн 0.00009 хувиар
550 саяас 600 сая хүртэл төгрөг	Суурь 2 795 төгрөг дээр 550 саяас давсан үнийн дүнгийн 0.00008 хувиар
600 саяас 650 сая хүртэл төгрөг	Суурь 2 835 төгрөг дээр 600 саяас давсан үнийн дүнгийн 0.00007 хувиар
650 саяас 700 сая хүртэл төгрөг	Суурь 2 870 төгрөг дээр 650 саяас давсан үнийн дүнгийн 0.00006 хувиар
700 саяас 750 сая хүртэл төгрөг	Суурь 2 900 төгрөг дээр 700 саяас давсан үнийн дүнгийн 0.00005 хувиар
750 саяас 800 сая хүртэл төгрөг	Суурь 2 925 төгрөг дээр 750 саяас давсан үнийн дүнгийн 0.00004 хувиар
800 саяас 850 сая төгрөг хүртэл	Суурь 2 945 төгрөг дээр 800 саяас давсан үнийн дүнгийн 0.00003 хувиар
850 саяас 900 сая хүртэл төгрөг	Суурь 2 960 төгрөг дээр 850 саяас давсан үнийн дүнгийн 0.00002 хувиар
900 саяас 950 сая хүртэл төгрөг	Суурь 2 970 төгрөг дээр 900 саяас давсан үнийн дүнгийн 0.00001 хувиар
950 саяас 1 тэрбум хүртэл төгрөг	Суурь 2 975 төгрөг дээр 950 саяас давсан үнийн дүнгийн 0.000009 хувиар

1 тэрбум төгрөгөөс дээш	Суурь 2 980 төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнгийн 0.000008 хувиар
-------------------------	---

“Засгийн газрын өрийн хэрэгслийг тусгаарлан бүртгэх журам”-ын хавсралт 2

Гэрээ дүгнэсэн актаар Засгийн газрын өрийн хэрэгслийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх тохиолдолд тооцох шимтгэл

50 сая хүртэл төгрөг	5 хувь
50 саяас 100 сая хүртэл төгрөг	Суурь 2 500 000 төг дээр 50 саяас давсан дүнгийн 4,5 хувиар
100 саяас 150 сая хүртэл төгрөг	Суурь 4 750 000 төг дээр 100 саяас давсан үнийн дүнгийн 4 хувиар
150 саяас 200 сая хүртэл төгрөг	Суурь 6 750 000 төг дээр 150 саяас давсан үнийн дүнгийн 3,5 хувиар
200 саяас 250 сая хүртэл төгрөг	Суурь 8 500 000 төг дээр 200 саяас давсан үнийн дүнгийн 3 хувиар
250 саяас 300 сая хүртэл төгрөг	Суурь 10 000 000 төг дээр 250 саяас давсан үнийн дүнгийн 2,5 хувиар
300 саяас 350 сая хүртэл төгрөг	Суурь 11 250 000 төг дээр 300 саяас давсан үнийн дүнгийн 2 хувиар
350 саяас 400 сая хүртэл төгрөг	Суурь 12 250 000 төг дээр 350 саяас давсан үнийн дүнгийн 1,5 хувиар
400 саяас 450 сая хүртэл төгрөг	Суурь 13 000 000 төг дээр 400 саяас давсан үнийн дүнгийн 1 хувиар
450 саяас 500 сая хүртэл төгрөг	Суурь 13 500 000 төг дээр 450 саяас давсан үнийн дүнгийн 0.9 хувиар
500 саяас 550 сая хүртэл төгрөг	Суурь 13 950 000 төг дээр 500 саяас давсан үнийн дүнгийн 0.8 хувиар
550 саяас 600 сая хүртэл төгрөг	Суурь 14 350 000 төг дээр 550 саяас давсан үнийн дүнгийн 0.7 хувиар
600 саяас 650 сая хүртэл төгрөг	Суурь 14 700 000 төг дээр 600 саяас давсан үнийн дүнгийн 0.6 хувиар
650 саяас 700 сая хүртэл төгрөг	Суурь 15 000 000 төг дээр 650 саяас давсан үнийн дүнгийн 0.5 хувиар
700 саяас 800 сая хүртэл төгрөг	Суурь 15 250 000 төг дээр 700 саяас давсан үнийн дүнгийн 0.4 хувиар
800 саяас 900 сая хүртэл төгрөг	Суурь 15 650 000 төг дээр 750 саяас давсан үнийн дүнгийн 0.3 хувиар
900 саяас 1 тэрбум төгрөг хүртэл	Суурь 15 950 000 төг дээр 800 саяас давсан үнийн дүнгийн 0.2 хувиар
1 тэрбум төгрөгөөс дээш	Суурь 16 150 000 төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс дээш үнийн дүнгийн 0.1 хувиар